



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/08

Өмнөдэлгэр сум

Дотоод хяналтын баг байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай журам" -ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн 2025-2026 оны хичээлийн жилийн дотоод хяналт шалгалт хариуцаж ажиллах багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч: О.Бүрэнбаяр (Математикийн багш)

Гишүүд: Л.Шинэцэцэг (Эмч)

Г.Эрдэнэшагай (Нийгмийн ухааны багш)

Я.Гансүх (Бага ангийн багш)

С.Тэгшжаргал (Бага ангийн багш)

П.Батмөнх (Сэтгэлзүйч)

Нарийн бичгийн дарга: Д.Отгонжаргал (Биологийн багш)

2. Сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөх, хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа захиргааны хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг хамт олонд мэдээлж ажиллахыг дотоод хяналтын багийн ахлагч (О.Бүрэнбаяр)-т даалгасугай.

3. Сар бүрийн ажлын өдрүүдэд дотоод хяналтын багийн ахлагчийг нийт 16, гишүүд тус бүрийг сард нийт 8 илүү цагт ажил үүрэг гүйцэтгүүлж, ажил үүргээ гүйцэтгэсэн цагийн тооцоог хянан баталгаажуулж, тайлан, гүйцэтгэлийг үндэслэн тухайн жилийн цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг зохих журмын дагуу олгохыг нягтлан бодогч (Б.Сэр-Од)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Д.ШИЖИРТУЯА